



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ЖИНСТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2022 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/14

Бодь

Засаг даргын дэргэдэх дотоод хяналтын  
зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.10, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.2.3, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журмын 4.1 дэх хэсгийг хэрэгжүүлэхээр ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төсөвт албан байгууллагуудад хяналт шалгалт хийж удирдлага арга зүйгээр хангаж зөвлөн туслах Засаг даргын дэргэдэх дотоод хяналтын зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч – Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга – Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүд – Санхүү албаны дарга

Хууль, эрх зүй дотоод асуудал хариуцсан ажилтан

Архив, бичиг хэргийн эрхлэгч

Нийгмийн бодлогын ажилтан

Хэсгийн төлөөлөгч

2.Дотоод хяналт шалгалтыг улирал бүр тогтмол зохион байгуулж шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг буруутай этгээдүүдэд танилцуулж хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч, ажлын хэсгийн ахлагч (Н.Сумъяа)-д даалгасугай.

ДАРГА Р.БАТЖАРГАЛ



642201005